



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/15

Биндэр сум

**Хяналт шалгалт хийх
ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн журмын 3 дугаар зүйлийн 3.4.3 дахь заалт, 3.5 дахь заалт, 4 дүгээр зүйлийн 4.3 дахь заалт, 4.4, 4.5, 4.6 дахь заалт, 6, 8, 9, 10, 11 дүгээр заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2026 оны Малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээний ажилд хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	М.Отгонбаяр	Засаг даргын орлогч
Гишүүд:	Н.Болормаа	Баян-Өндөр багийн Засаг дарга
	Э.Мөнгөншагай	Мандалхаан багийн Засаг дарга
	Ж.Ганзоригт	Баянгол багийн Засаг дарга
	Х.Амарзаяа	Дэлгэрхаан багийн Засаг дарга
	Б.Тунгалаг	Баян-Өндөр багийн Засаг дарга
Нарийн бичгийн дарга:	А.Гэрэлмаа	Хөдөө аж ахуйн тасгийн дарга

2.Малын тоо толгойн албан татварын хөрөнгө оруулалтаар 2023 он, 2024 онд дутуу хийгдсэн ажлуудад хяналт тавьж холбогдох материалыг бүрдүүлэн 2026 оны 02 дугаар сарын 12-ны дотор багтаан танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (М.Отгонбаяр)-т үүрэг болгосугай.

3.Хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө гарган, хууль тогтоомжийн дагуу ажлыг зохион байгуулж, үр дүнг танилцуулан ажиллахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ДЭМБЭРЭЛСАЙХАН

